



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 62

Баруун-Урт

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсгийн “ж”, 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.7, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтууд, Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2019-2022 онд хэрэгжих “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгах, гадаад, дотоодын хөтөлбөр, Олон улсын байгууллагатай хамтран ажиллах замаар шийдвэрлэж, хэрэгжилтийн тайланг жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Ж.Эрдэнэбаатар/-д даалгасугай.

ДАРГА

Б.МӨНХБАТ



01000123

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны
10. сарын 15 өдрийн 62 дугаар
тогтоолын хавсралт

**ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР
/2019-2022/**

Нэг. Нийтлэг үндэслэл:

Улсын Их Хурлаас 2011 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсанаар аймгийн түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хороо, сумдад дэд хороо байгуулагдан ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлагдан гарсан нь орон нутаг, салбар бүрийн түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх бодлого зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа тодорхойлох эрх зүйн үндэслэл болж байна.

Мөн “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.8–т “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.”-гэсэн зорилтыг тусгасан байна.

Манай аймгийн нийт иргэдийн 49.2 хувийг эрэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн дундаж наслалт, эмэгтэйчүүдийн дундаж наслалтаас 9.8 жилээр богино байна. Мөн аймгийн хэмжээнд жилд нас барж буй иргэдийн 60.2 хувийг эрэгтэйчүүд эзэлж буй нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал анхаарал татаж буйг илтгэж байна.

Нас баралтын тэргүүлэх шалтгааныг авч үзвэл :

Хорт хавдар 30% (8.2-11)

Цусны эргэлтийн тогтолцооны өвчин 16% (3.1) байна.

Сүүлийн жилүүдэд хөвгүүдийн сургууль завсардалт буурч, их, дээд сургуульд суралцагчдын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсэнээр жендэрийн зөрүүтэй байдал буурч байгаа хэдий ч боловсролын салбарт ажиллагсадын хүйсийн тэнцвэрт байдал улс орны хэмжээнд ч, орон нутгийн хэмжээнд ч анхаарал татсан хэвээр байна.

Аймгийн Цагдаагий газрын статистик мэдээллээр 2018 онд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо 2017 онтой харьцуулахад буурсан хэдий ч уг асуудлыг цаашид эрчимтэй бууруулах, таслан зогсоох хэрэгцээ шаардлага байсаар байна. Мөн Хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах байрыг орон нутагт байгуулаагүй нь хохирогчдод төрийн үйлчилгээ хүрэхгүй байх, бүр цаашилбал тэдний амь насанд эрсдэл учрах нөхцөл байдлыг бий болгохыг үгүйсгэх аргагүй юм.

Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны идэвх сайжирч буй хэдий ч шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй хэвээр байсаар байна. Энэ нь аймгийн 2016-2020 оны аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн 5.5 хувийг эмэгтэйчүүд эзэлж буйгаас тодхон харагдаж байна. Гэхдээ зарим сумдын түвшинд нэлээдгүй ахиц гарч тухай шатны

төлөөлөгчдийн 50-с дээш хувийг эмэгтэйчүүд эзэлж буй дэвшил гарч буйг дурьдахгүй өнгөрч болохгүй.

Хэдийгээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн орчин бүрдэж, орон нутагт жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хороо, дэд хороод ажиллаж буй хэдий ч уг ажлыг цаашид эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага байсаар байна.

Тус аймгийн хувьд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллагын идэвх оролцоо, чадавх сул, иргэд, шийдвэр гаргах түвшинд ажиллагсадын мэдлэг хандлага дутмаг, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр сургагч багш бэлтгэх тогтолцоо бүрдээгүй байгааг цаашдын үйл ажиллагаанд зайлшгүй харгалзах шаардлагатай байна.

Иймд Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар, Ахмадын хороотой байгуулсан гурвалсан гэрээгээр “Орон нутгийн жендэрийн нөхцөл байдлыг тодорхойлох судалгаа”-ны үр дүн, аймгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөрийг боловсрууллаа.

Хууль эрх зүйн үндэслэл

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 129 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Холбогдох бусад эрх зүйн актууд;

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1 Хөтөлбөрийн зорилго:

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг эрчимжүүлж, төр иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэн, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангахад оршино.

2.2 Хөтөлбөрийн зорилт

Зорилт 1. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх;

Зорилт 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлж, хамтын ажиллагааг дээшлүүлэх

Зорилт 3. Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх

Зорилт 4. Жендэрт суурилсан хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд төр, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах

2.3 Хөтөлбөрийн хэрэгжүүлэх хугацаа: 2019-2022 он

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.1. Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.1 Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм соёл, эдийн засаг, гэр бүлийн хүрээнд эрэгтэй, эмэгтэйчүүдэд тулгамдаж байгаа асуудалд суурь судалгаа хийж, холбогдох байгууллагуудад танилцуулан үйл ажиллагаанд тусгах арга хэмжээ авах;

3.1.2 Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх асуудлыг төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд тусгуулах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх

3.1.3 Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгох, иргэнийг ажилд авахад жендэрээр ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх тухай заалтыг аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн хэлэлцээрт тусган, хэрэгжилтийг хангах

3.1.4 Эрэгтэйчүүдийн өвчлөл, нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлийг судалж, Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, боловсон хүчнийг үе шаттайгаар сургах

3.1.5 Олон хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, бага орлоготой, өрх толгойлсон эцэг (эх)-ийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг дэмжих;

3.1.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж, нөхцлийг сайжруулахад анхаарах

3.2 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлж, хамтын ажиллагааг дээшлүүлэх зорилтыг хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.1 Төрийн албан хаагчдыг жендэрийн анхан шатны мэдлэг олгох сургалтанд үе шаттайгаар хамруулах

3.2.2 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр сургагч багш бэлтгэх, энэ чиглэлээр гарсан иргэний нийгмийн байгууллагын санал, санаачлалыг дэмжих

3.2.3 Иргэний нийгмийн байгууллагуудыг жендэрийн дүн шинжилгээ, нөлөөлөл, мониторингийн чиглэлээр мэргэшүүлж, хамтран ажиллах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг ИНБ-аар гүйцэтгүүлэх

3.2.4 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр явуулж буй тэргүүний туршлагыг түгээн дэлгэрүүлж, сайн ажиллаж буй сум, байгууллага, удирдах албан тушаалтан, албан хаагчийг урамшуулах

3.2.5 Бүх нийтийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр жендэрийн асуудлаар тусгайлсан нийтлэл, нэвтрүүлгийг гаргах;

3.2.6 Хүйсээр ангилан гарч буй Статистик тоо мэдээллийг нэмэгдүүлэхэд анхаарч, мэдээллийн санг бодлого боловсруулагчдад хүргэх арга хэлбэрийг сайжруулах

3.2.7 Гэр бүлийн үнэ цэнэ, хамтын амьдралын утга учир, эцэг, эхийн хамтын үүрэг, хариуцлагыг таниулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж, үр хүүхдээ хөдөлмөрч, шударга, ёс суртахуунтай иргэн болгон төлөвшүүлэн хүмүүжүүлж байгаа гэр бүлийг сурталчлах, урамшуулах

3.2.8 Жендэрийн асуудлаар мэргэшсэн мэргэжилтнүүдийн клуб ажиллуулахыг дэмжих

3.3 Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3.1 Агентлаг, алба, сумын ИТХурал, Засаг даргатай байгуулах хамтран ажиллах гэрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжилтийг хангах тухай заалтыг жил бүр тусгаж, гүйцэтгэлийг үнэлэх

3.3.2 Бодлого төлөвлөлт, хүний нөөц, төсөв санхүүгийн чиглэлээр ажиллаж буй мэргэжилтэн, албан хаагчдыг Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлтийн сургалтанд үе шаттай хамруулах

3.3.3 Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнд зарцуулах чиглэл баримтлах

3.4 Жендэрт суурилсан хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд төр, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.4.1 Аймгийн Цагдаагийн газрын дэргэд хүчирхийлэлд өртсөн иргэдийг "Түр хамгаалах байр" байгуулан, ажиллуулах

3.4.2 Гэр бүлийн эерэг харилцааг төлөвшүүлэх чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах

3.4.3 Агентлаг, алба, аж ахуйн нэгж, байгууллагад хүчирхийлэл, түүний дотор ажлын байр дахь бэлгийн дарамт гарахаас сэргийлэх, хохирогчийн хүсэлт, гомдлыг ажил олгогчийн зүгээс шийдвэрлэх орчныг бүрдүүлэх;

3.4.4 Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх;

Дөрөв. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр дараах үр дүнд хүрнэ:

4.1.1. Жендэрийн талаарх олон нийтийн хэвшмэл ойлголт, хандлага өөрчлөгдсөн байна.

4.1.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавх бэхэжсэн байна.

4.1.3. Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах байр орон нутагт байгуулагдсан байна.

4.1.4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа дээшилсэн байна.

4.1.5 Орон нутагт нийгмийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын чадавх дээшилсэн байна.

4.2. Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2018)	Зорилтот түвшин (2020)	Зорилтот түвшин (2022)	Хэрэгжүүлэх байгууллагууд
1	Жендэрийн асуудлаар бэлтгэгдсэн сургагч багш	Тоо	-	5	20	Жендэрийн салбар хороо
2	Хөдөлмөрийн дотоод журамдаа хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн дарамт, хөдөлмөрийн мөлжлөг, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх асуудлыг тусгасан байгууллага, аж ахуйн нэгж	Хувь	ТБ-10 % ААНБ-	ТБ -80 % ААН-10%	ТБ -100 % ААН-40%	АЗДТГ АОЭХ ҮЭХ Сумдын ЗДТГ МХГ ХХҮГ
3	Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн тасаг, кабинет байгуулах	Тоо	1	1	2	ЭМГ, Нэгдсэн эмнэлэг
4	Жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд орон нутаг дахь төрийн бус байгууллагаас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тоо	Тоо	-	1	1	Аймгийн ЗДТГ, Жендэрийн салбар хороо ТББ
5	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг хамгаалах байр	Тоо		1	1	ЦГ, ГБХЗХГ

Тав. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

5.1.4. бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

6.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих, хэрэгжилтийн явцыг тайлагнах, санал оруулах үүргийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Аймгийн салбар хороо хариуцан гүйцэтгэнэ.

6.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг үл тэвчих, жендэрийн хэвшмэл ойлголт, хандлагыг арилгах чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн оролцоог хангах, тэдний санал санаачилгыг дэмжин хамтарч ажиллахыг орон нутгийн төрийн байгууллагууд хариуцан гүйцэтгэнэ.

6.3 Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгах замаар шаардагдах зардлыг төсөвт тусгана.

6.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн идэвх санаачилгыг дэмжих, орон нутгийн хэвлэл мэдээллээр сурталчилах ажлыг аймгийн Олон нийттэй харилцах алба хариуцна.

6.5. Салбар хороо нь дэд хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн тайланг бүтэн жилээр гаргана

6.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд тайлагнахыг аймгийн Салбар хороо хариуцна.

Долоо. Дэд хөтөлбөрийн хяналт-шинжилгээ үнэлгээ

7.1. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах аймгийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явц болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг АЗДТГ-ын ХШҮДАХ-ээс жил тутам хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

7.2. Дэд хөтөлбөр хэрэгжих хугацаанд хөндлөнгийн үнэлгээг Төрийн бус байгууллагаар 1 удаа хийлгэх ажлыг аймгийн Жендэрийн салбар хороо тухайн жилийн үйл ажиллагаандаа төлөвлөнө.